



ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ

**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ 08 ДУГААР
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**



СӨҮЛ ХОТ

2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр

Тус төв нь Монгол Улсын болон БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам хоорондын “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны дагуу БНСУ-д ажиллах хүч илгээх тухай” харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд ажил олгогч, ажилтан хоёрын хооронд байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлтийг хангуулах, хяналт тавих, БНСУ-д ажиллаж амьдарч буй Монгол Улсын иргэдийг хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалд хамруулах, нутаг буцсан иргэдэд суугаа орны Үндэсний тэтгэврийн албанд төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг буцаан авах зөвлөгөө мэдээллээр хангах, БНСУ-д ажиллаж амьдарч буй иргэдийн эрх ашгийг хамгаалах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, бусад холбогдох хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулж ажилласан.

- I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
- II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
- III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ:

1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн харилцааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

1.1.1 Тайлант хугацаанд БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 29 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг цахимаар, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төвд ирсний дараах сургалтыг танхимаар зохион байгуулж 35 гэрээт иргэнийг хамруулан дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгсөн. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны товч танилцуулга
- Солонгос Улсын хууль, дүрэм, журам
- Үйлдвэрлэлийн осол, үйлдвэрлэлийн ослын даатгал, ХАБЭА, ослоос урьдчилан сэргийлэх
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Ур чадвартай ажиллах хүч E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх гэх мэт.

Мөн сургалтад хамрагдсан 30 гэрээт ажилчинд сургалтын материалыг цахим шуудангаар илгээсэн.

1.1.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2024 оны 08 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт **244** иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд, холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын газраас оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин, нутаг буцах зардал, үйлдвэрлэлийн ослын даатгал, гэнэтийн ослын даатгалуудын нөхөн олговор, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс, эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээ зэрэг хэлбэрээр нийт **198,508,487** воныг Монгол Улсын **33** иргэнд олгуулсан.

Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай холбоотой өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байх үедээ гэнэтийн ослоор нас барсан Т.М-ийн ар гэрт нөхөн олговрын 15,000,000 вон олгуулсан.

Үйлдвэрлэлийн ослын даатгалаас ажилгүйдлийн тэтгэмж, эмчилгээний төлбөрт хөдөлмөрийн гэрээт ажилчин О.Б, Ц.Х нарт нийт 10,096,716 воныг олгуулсан.

БНСУ-д хууль бусаар ажиллаж байгаа иргэдээс ирсэн өргөдөл, гомдол

Хууль бусаар ажиллаж амьдарч байгаад уушгины хүнд хэлбэрийн үрэвслийн улмаас нас барсан иргэн М.Ө-ын эмчилгээний зардал 60,000,000 вон болон чандарлах зардлыг тус улсын нийгмийн халамжийн сангаас гаргуулж, чандрыг ар гэрт нь хүлээлгэн өгөх ажилд туслалцаа үзүүлсэн.

Олон улсын зочид буудалд хууль бусаар ажиллаж байхдаа баригдаж цагаачлалын албанд хүргэгдсэн иргэдэд нийтдээ 7,550,000 воныг олгуулсан.

1.1.3 Төрийн үйлчилгээг үзүүлэх зорилгоор Монгол Улсаас БНСУ-д суугаа Элчин сайд С.Сүхболдын хамтаар тус төвийн удирдлага, Нийгмийн даатгалын тасгийн дарга, холбогдох мэргэжилтнүүд 2024 оны 08 дугаар сарын 01-03-ны өдрүүдэд Чэжү хотноо ажиллаж буй 80 иргэнд “Явуулын үйлчилгээ”-г үзүүлсэн.

2024 оны 08 дугаар сарын 11-ний өдөр Кинтекс үзэсгэлэнд БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн газраас зохион байгуулсан “Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо үүсэж хөгжсөний 20 жилийн ойн арга хэмжээ”-нд оролцож 10 гаруй монгол иргэнд байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг сурталчлан, холбогдох гарын авлагыг хүргэсэн.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр тогтвор суурьшилтай ажиллан ур чадвартай ажиллах хүчний визний ангилал руу шилжүүлэх ажлын хүрээнд:

1.2.1 Е-9 визээс мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 визний статус руу өөрчлөх хүсэлтэй 12 иргэнтэй холбогдож К-пойнт оноог тоолон, Топик болон Нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн шалгалтад бэлтгэх суваг, шалгалтын хуваарь зэрэг хэрэгцээт мэдээлэл, зөвлөгөөг өгч, бүртгэлийн санд бүртгэв.

1.2.2 Е-7-4 визний мэдээлэл солилцох сошиал групп шинээр үүсгэсэн.

3. БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэдэд гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлж, дэмжлэг туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд:

1.3.1 2024 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Нийслэлийн гэр бүл хөгжлийн газрын мэргэжилтэн Н.Анужинтай уулзалт хийж, БНСУ-д зохион байгуулагдсан “Сөүлийн загварын 7 хоног” арга хэмжээнд дэмжлэг үзүүлж мэдээллийг түгээж ажилласан.

1.3.2 БНСУ-д оршин суугаа Монгол Улсын иргэдэд сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэх чиглэлээр, ганцаарчилсан сэтгэл засал 2 хүнд утсаар хийж, 1 хүнд зөвлөгөө мэдээлэл өгсөн ба сэтгэл гутрал болон түгшилтийг илрүүлэх сорил 3 удаа хийсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн сар тутмын тоон мэдээ

/2024 оны 08 дугаар сар/

№	Агуулга	Дүн
1	Иргэдэд олгуулсан мөнгөн дүн	198,508,487 /33 иргэнд/
2	Шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	244

II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.1 Тайлант хугацаанд нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд 47 иргэнийг шинээр хамруулан “Солонгос Улсад гэрээгээр ажиллагсдын программ”-д мэдээллийг бүртгэн гэрээ байгуулав. Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд даатгуулсан иргэдэд шинээр 44, гэрээний хугацаа сунгасан 30, ажлын байраа сольсон, гэрчилгээг гээж үрэгдүүлсэн, албан байгууллага нь хүсэлт гаргасан 7 даатгуулагчид Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг тус тус бичиж олгов.

2. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах ажлын хүрээнд:

2.2 Нийт 42 иргэнийг сайн дурын нийгмийн даатгалд шинээр хамруулав. БНСУ-ын ААН-д хөдөлмөр эрхэлдэг 38 даатгуулагчийн хүсэлтийн дагуу Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулсан гэрчилгээг бичиж олгов.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах ажлын хүрээнд:

2.3.1 НДЕГ-ын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар тус тасгийн 2024 оны орлогын төлөвлөгөө 4,997,799,000.00 төгрөгөөр батлагдсан бөгөөд сар бүрийн орлогын төлөвлөгөө 416,483,250.00 төгрөг болно.

Тус тасаг нь тайлант хугацаанд тэтгэврийн даатгалын шимтгэл 48,810,150.00 вон буюу 120,561,070.50 төгрөг, сайн дурын даатгалын шимтгэл 115,939,252.00 төгрөг, нийт 236,500,322.50 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлж, шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 57 хувиар биелүүлсэн.

Хүснэгт-1

2024.08.31-ний өдрийн байдлаар /ханш-2,47/

	Албан журам			Сайн дур	НИЙТ ДҮН	Биелэлтийн хувь	Ханш
	Төгрөгөөр	Воноор	Төгрөгөөр	Төгрөгөөр	Төгрөгөөр		
8	416,483,250.00	48,810,150	120,561,070.50	115,939,252.00	236,500,322.50	57	2.47

2.3.2 Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын ажил олгогчдод тухайн сарын болон өмнөх саруудын шимтгэл төлөхийг сануулж, 595 ширхэг нэхэмжлэл факсаар илгээн, нийт 785 даатгуулагчтай шимтгэл төлөхийг шаардаж утсаар холбогдсон.

2.3.3 Нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн 08 дугаар сарын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн сан дахь холбогдох дансанд шилжүүлэн, тайлан мэдээг гарган НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн.

4. Тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчдад баримт олгох ажлын хүрээнд:

2.4 Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж авах эрх үүссэн 4 даатгуулагчид зохих журмын дагуу даатгуулагчийн тодорхойлолтыг гаргаж, шаардлагатай бичиг баримтыг монгол хэл рүү хөрвүүлж өгөв.

5. Иргэд, даатгуулагчид болон ажил олгогчдод нийгмийн даатгалын талаар мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх, тэдний хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд:

2.5 Тайлант хугацаанд нийт давхардсан тоогоор 316, үүнээс 308 иргэн, даатгуулагч, ажил олгогчид утсаар, 8 иргэн, даатгуулагчид биечлэн Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар болон бусад төрлийн мэдээлэл, заавар, зөвлөгөө өгч, сурталчилгааны материал тараан ажиллав.

6. БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанаас шимтгэлийн буцаан олголтыг олгуулах ажлын хүрээнд:

2.6 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар хүсэлт ирүүлж ҮТА-д илгээсэн 204, 205, 206 дугаар ээлжийн 12 иргэний 43,3 сая вон бүрэн шийдвэрлэгдэж, иргэдийн дансанд шилжсэн байна.

III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сахилга хариуцлагыг чангатгах, ажлын бүтээмж, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн ажлын хүрээнд:

3.1.1 Монгол Улсын Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” 01 дүгээр албан даалгаврын хүрээнд “БНСУ дахь хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, ажилтнуудын сахилга хариуцлагыг сайжруулах төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар нэгтгэн удирдлагад танилцуулав.

3.1.2 БНСУ-ын хөдөлмөрийн харилцаанд үйлчилж буй 138 хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, журмын жагсаалтыг орчуулж гаргасан.

3.1.3 БНСУ-ын Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг орчуулж байна.

3.1.4 БНСУ-ын Аж үйлдвэр, хүний нөөцийн хэрэг эрхлэх газраас гаргасан Олон улсын хүний нөөцийн статистик эмхэтгэлээс монгол иргэдэд холбогдох тоон мэдээлэл, судалгааг гаргав.

3.1.5 БНСУ-ын цагаачлалын албанаас тоон мэдээллүүдийг авч нэгтгэн, өмнөх сарын мэдээллийг шинэчлэв.

3.1.6 Олгогдоогүй цалин хөлсний маргаан шийдвэрлэх шат дараалал, эрүүгийн хэрэг үүсгэх, БНСУ-ын хууль зүйн туслалаа үзүүлэх төвд хандан өргөдөл шийдвэрлэх, татварын буцаан олголт авах, ур чадвартай ажиллах хүчний виз рүү хөрвөх мэдээлэл зөвлөгөө өгөх, оноо тоолоход зөвлөн туслах аргачлал, цахимаар өргөдлийг хүлээн авах, шийдвэрлэх аргачлал, ажлын хүснэгтийг өдөр тутам хөтлөх аргачлал зэрэг 21 төрлийн аргачлал, зааврыг боловсруулсан.

3.1.7 Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 29 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 20 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 29,844 хандалт авсан.

3.1.8 08 дугаар сарын 01, 29-ний өдрүүдэд тус улсад үйл ажиллагаа явуулдаг “Гэрээний залуусын нэгдэл” ТББ, “E9 ray Mongolia” компанийн фэйсбүүк хуудсуудын ээлжит “LIVE” нэвтрүүлгүүдээр Хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлуудаар болон Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулсан.

3.1.9 БНСУ-ын Ерөнхийлөгчийн тэтгэврийн шинэчлэлийн талаар хийсэн хэвлэлийн хурлын мэдээг орчуулж, бодлогын арга хэмжээ, статистик мэдээлэл, шинэчлэлийн төлөвлөгөөний талаар судалгаа хийж орчуулан яаманд хүргүүлсэн. Шинэчлэлийн нарийвчилсан төлөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтийг Үндэсний тэтгэврийн албаны гадаад харилцааны газарт цахимаар хүргүүлсэн.

3.1.10 Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх 4 иргэний хүсэлтийг хүлээн авч, бүртгэлийг баталгаажуулан, иргэдэд бүртгүүлэх кодыг холбогдох программаас илгээв.